



Дэлхийн шуудан холбооноос 55 дахь удаагаа зарлаж буй олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичлэгийн уралдааныг Харилцаа холбооны зохицуулах хороо Монгол Шуудан ХК-тай хамтран улсын хэмжээнд 10 дахь жилдээ зохион байгууллаа.

Энэ жилийн уралдаан дижиталжиж буй дэлхий ертөнцөд цахим хэрэглээ, техник технологи, хиймэл оюунаас илүү хүн хоорондын холбоо, амьд харилцаа яагаад чухал талаар эргэцүүлэн бодож, үзэл бодлоо илэрхийлэх “Дижитал ертөнцөд хүн хоорондын харилцаа яагаад чухал болох талаар найздаа захидал бичээрэй” сэдвийн хүрээнд зарлагдсан юм.



Захидал бичлэгийн уралдаан 2026 оны хоёрдугаар сарын 1-нээс гуравдугаар сарын 15-ны өдрийг дуустал үргэлжилсэн бөгөөд Монгол Шуудан ХК-ийн Улаанбаатар хот болон орон нутгийн бүх салбаруудаар нийт 2780 сурагч захидал ирүүлжээ.

Захидлуудыг уралдааны удирдамжийн дагуу шуудангийн хаягаа зөв бичсэн эсэхээр хянаж эхний шатны шалгаруулалтыг хийсэн бол хоёр дахь шатны шалгаруулалтыг шүүгчдийн бүрэлдэхүүн захидлын бүтэц, найруулга, сэдэв агуулгын судалгаа, асуудлыг тодорхойлсон байдал, хэрэгжих боломж шийдэл, хиймэл оюун болон бусад эх сурвалжаас хуулсан эсэхийг шүүж, шилдэг 15 захидлыг шалгаруулсан юм.

Үүнд:



**Захидлын уралдааны Тэргүүн байр буюу Монгол Улсын Үндэсний ялагч:**

Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч Нямаагийн Нэмүүлэн



**Дэд байранд:**

1. Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 6а ангийн сурагч С.Төгсжаргал
2. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10а ангийн сурагч Н.Гэрэлсүрэн



#### Гуравдугаар байранд:

1. Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8а ангийн сурагч М.Лхамсүрэн
2. Завхан аймгийн Улиастай сумын Ерөнхий боловсролын “Чандмань–Эрдэнэ” сургуулийн 10в ангийн сурагч Ю.Ариунгоо
3. Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 7а ангийн сурагч О.Эгшиглэн



**Дөрөвдүгээр байранд:**

1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Мөнхцацрал
2. Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 17-р сургуулийн 9д ангийн сурагч Ш.Билгүтэй
3. Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч Т.Шинэцэцэг
4. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10б ангийн сурагч Х.Номин-Эрдэнэ



#### Тавдугаар байранд:

1. Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 17-р сургуулийн 9д ангийн сурагч Э.Солонго
2. Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч М.Болор-Од
3. Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 7д ангийн сурагч А.Нандин-Эрдэнэ
4. Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын 20-р сургуулийн 9е ангийн сурагч М.Нарансолонго
5. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 6а ангийн сурагч Э.Энх-Үжин

Дэлхийн шуудан холбооноос зарласан олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичлэгийн уралдааны шилдгүүдийг зохион байгуулагчид 2026 оны 4-р сарын 22-ны өдөр хүлээн авч шагналыг гардуулсан бөгөөд захидлын уралдааны нэвтрүүлэг UBS телевизээр 2026 оны 4-р сарын 30-ны пүрэв, 5-р сарын 4-ний даваа гарагт тус тус гарна.



Мөн тэргүүн байр эзэлсэн үндэсний ялагч Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч Н.Нэмүүлэнгийн бичсэн захидлыг англи хэл рүү хөрвүүлэн Дэлхийн шуудан холбооны олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичлэгийн уралдаанд илгээнэ.

Телевизийн нэвтрүүлэгт зохион байгуулагчдын төлөөлөл болон ХХЗХ-ны Шуудангийн зохицуулалтын газрын дарга П.Цэрэнням, шүүгчдийн төлөөллөөр Нийслэлийн ерөнхий боловсролын 40-р сургуулийн Монгол хэл бичиг, уран зохиолын багш, боловсрол судлалын магистр Б.Дуурсахмаа оролцсон бол “Focus on the family Mongolia” байгууллагын хамтын ажиллагаа хариуцсан захирал, сэтгэл зүйч Д.Энхжин уралдааны сэдвийн хүрээнд сурагчдын асуултад хариулж, цахим орчны зөв зохистой хэрэглээ, хүн хоорондын нандин харилцааны талаар зөвлөгөө өглөө.

Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
9а ангийн сурагч Нямаагийн Нэмүүлэнгийн захидал


Сайн байна уу? Гэрбээд хатуу хөнгөрсөн найз минь. Чи минь гол марин эм-  
дээ гол цогтой шинэлсэн үү? Найз нь өдөө гэрээг шинэ төвийн дуутай  
халт хайртай хээр буурайтайгаа болон гэр бүлийнхэнтэйгээ сайхан шинэчлэн  
Миний хувьд анх удаа цаасан дээр өөрийнхөө гараар талд захидал бичиж  
байлаадаа маш их баяртай байна. Үнэнд найз нь талд дигжитал ертөнц болон  
хүн хоорондын харилцааны талаар өөрийнхөө үрэл бодлыг бичиж гэсэн юм аа.  
Цахил сурагч үүсч хөгжснөөр бидний амьдралд зөндөө сайхан зэрэг гайхалтай  
зүйлүүд бий болсон. Мэдээ мэдээлэл, дэлхий ертөнцийн сонин хахнаас чал алдал-  
гүй уншиж, мэдлэг боловсролоо ч их хөгжлөө оруулж байлаа билээ. Тусуудтай  
маш хурдан холбогдож, мөнгөтэй холбоотой зарим асуудлуудыг гэрээгээ зохи-  
чуулж нь бидний амьдралыг үнэлээр хөгжлийнх байлаа. Дигжитал ертөнцийн  
зэрэг талыг нь бидэнд байвал маш их. Харин сөрөг тал нь ч маладгүй үүнээ-  
сээ их байж байршилгүй юм талаар гэвэл хуучин цахил ертөнцөд хэт дотг-  
сонгоого болж эрүүл мэндээрээ хөвчрл байлаа нь мэдэхийг харалддаг. Дэлгэцийн  
халаарал бүхий хүний тэвчлэг нь бага багаар гэмтлэг байдлыг судлаагид олж  
илүүрсэн тухай уншсан. Мөн хүн хоорондын харилцаа бас хүртэл хөндий ч юм  
шил. Хийд харилцаа нь бидэнд дотно нөлөө үзүүлдэг бол цахил харилцаа нь  
дэлгэцийн цаанаас харилцаагараа ялгаатай. Түүн үгаснихаа цаанаас сэтгэл хөдөлгөө  
бодитоор мэдэхийнх гаддалгүй дүрт дүүдлага хийсэн ч мэдэхийнх нүүлдэг.  
Гарин үүлдээд яриад үнэлээр нэлнийгээ ямар байлааг илүү мэдэрл гаддал. Жагад  
хүнд хөвчр, зүйл тэвчлэгдэхэд талтай санаа зовно үзэг дүрээрээ гэж хэдэр. Чи  
миний хөвчүүд байсан бол ямар байлааг биеийн хэлэлжээр минь мэдэрл

айлгах байсан байхдаа Найз минь чи шилжин яваад 4 жил болжээ. Энэ хугацаанд  
бид хээр цахил талаар харилцаж байлаа гэж ч миний өөрчлөлийн мэдэрл гадал-  
-үгидээ хаяа үнэлдэг. Зуралнаас чинь гадна тэвчлэг чинь харж байлаа байвал  
дотгөөд ертөнцийн чинь өөрчлөлийн мэдэрлийн хүрл байна. Чалайл суналдаа  
байхад нүдийн чинь харж илээж, цураахыг чинь мэдэрл халтдаа чалил гэндөө  
зулаатай өнлөрүүдэл бичижээ. Мэдэхээр дигжитал ертөнц бол дүрээр ч нэл хэрэгээр  
харин амьд харилцаа бол хүн байхын эхлэг юм байна. Мүүр нарын хүүдасын  
эрлүүлж харал тусам тэнд байлаа зарим хүнүүс хуураа, будуураа дээрлэхүү  
ч юм шил. Сайн сайхан хүнүүс гэндөө ч бий. Гэндээ тэднийг хийнхэнэ мүүр  
чарал олж харна гэдэг барал гудлаа. Сошиал ертөнцөд сайхан дүр бүтээдэг  
мүү хүн ч байна, өөрийнхөө үрэл бодлыг төлөлтэй мэдэхийнхээрээ мүү бичиж-  
дөг ч хүн байна. Энгийн хүнүүс Фейсбүүк инстаграм нүүрээр бичлэг хийж  
амьт талыг болж байна. Зарим нь үнэлээр гол үлээр дүүрайлал болохээр  
зэрэг зүйлийн харуулдаг ч зарим нь амьт хөгжлөө олжж түүд юу ч хийлээс  
бүүрлүү харалддаг. Бодит үрэл нь мэдэхгүй байж нэлнийгээ дигжитал ертөнцөөр  
дээрлэхийнх мүүрлүү үрээр чутаадаг ч байна. Тийм болохээр энэ ертөнцөд ухаантай  
бэлтэй байхгүй бол хөвчрл болж эсвэл бүрхилдэлтэй гутралтай болох ч мүүрэнд.  
Сүүлийн үед тал хүн хүүрүүд ялаагүй цахил төлөлийнх дондох болсон. Цахил  
марийтай төлөлийн төлөлийн өрөнд орж амьт хөгжлөө талыгдэг ч гэндөө байдал  
гэсэн нь үнэлээр харилцаатай. Үнэнд бодохээр амьд харилцаа ямар их чухал гэж  
Тийнхэн үгидэлгүй байлаа мэт дигжитал ертөнцөөр ялаала ч үнэндээ ганцаардлыг  
бий болжж байна. Дэлгэцийн цаанаас хийнхэн сайхан элжж явуулсан ч хийнхэнэ

тэвэрлэлийн үрцэггүй Талтдаа байж баяр цинг жаргал зөвлөл зүгээр нь хам-  
гийн сайхан зүйлс төрлөө дуг шүүдэлдээ гэхэд хамт байгаа үедээ эхлээд  
нэлэгдээ шүүдэл үр гэхэд гаднахгүй Нэлнийгээ шүү рүү харж байлаа дараах  
заримтай хүр хэвэр байх Тарин дэлхийн цаанад юу ч билиж гадна Нелерил  
дүүр хэвээр сэтгэгдээ гандогтой үедээ шүүр хамт байх үед харлаж шүүдэл  
диг биендээ анхаарах хэлэлс тавих нь тухай байжээ Шиний бодлоор соншиа  
хэрэглээгээ зөв зохистой, сэлтэй болгох нь тухай асуудал нэл Байншгүй хэрэглээтэй  
үедээ амшигааг дусад үед нэл үнийнх зогсолт төлөгхөл илүүд үрээ нь дээр  
үзэгт нь дилжитэй Ертийн маш хурдацтай хөгжихийг амил туй нь их ч гэхээ  
тэнцвэртэй хандоггүй бол сүүдэртэй тал нь давамгайлсааг байлаа харалдаа ч байн  
Тарин амид харилцаа бол илүү дуралхан, үнэл үлртай, дурсалжтай хийнхэнэ  
илдрэлхийн илрхийнээ нэл илтернэт үүсгээг өинэ хүмүүсийн харилцаа илүү  
дотно байж тийн хөршийнхөөрөө өрж гарч, нэл тэрвэлхэн хүрэгдүүд хамтдаа төлөг  
диг биендээ илүү их анхаарах тавьдал байсан Дээр үед шүүдэн хэлбэр хүмүүсийн  
харилцааг илүү болж хамт харилцааг өртүүжээ өгдөл байж Захидаг билиж дур-  
туйнд хийж шүүдэн хэлбэргээр илгээ нь өржин үед хэрэгдсэн илт хэдий ч  
өсөн сайхан давуу талтай саналдсан Валаад гэхээ манай эгж өдөө болтол найруу-  
дгалаа захиал хэрэгж байдал Вэлхийн 10 жилийн болон өсүтэн чөлөөтх нь дурсалж  
тэр захидагддаа нь үдээг байдал гэхэн Эгж нэл удаа шүүрвэлхээ нэлм чөлөөтх  
байлааг захидагддаа үншээг ач жаргалтайгаар илгээгд байсан Би тухайн үедээ  
өйлгөөгүй ч өдөө бодогод эгж шинэ хүүхэд нагандээ эрлэг өдөөг дээрлэж байж  
Чатни захидаг нэл илгээг ч үтэсн байдал бол чөлөөт захидаг хэрэгж дурсалж

сэрлээж байдал байх нь  
Мөн чөлөөт захидаг билигдээ хүмүүс үр үрэл, найрууллын адралгүй, үрийн тавл-  
лалгүй чөлөөтэй сайхан бидгээ нь билийн сөгд тухай үүрэгтэй саналдсан Соншиа  
сүлжээнд автомат үрийн фондээр бидгээ бол чөлөөт захидаг нь тухайн хүнийгээ  
билийн гэхийл чөлөөт дээр үдээгээрээ хайхалтай Өдөө үед эхн эмар билийн гэхтэй  
болон нагас өөр хүмүүс барал илгээгүй Захианыгаа төлөгд хэлээг хэвээр сардаа  
нэл удаа чөлөөт захидаг харилцаж байа Би үдээгүй төлөгд тал дээр өлж бөл-  
гээр үдээг хурацаанд захидаг харилцаж дурсалж болжог үдээг Эгээ нэлэн чөлөөт,  
хадгалсан захидаг үнийнх ач жаргалтайгаар илгээгээ.

Захидаг билин: Виклада аймгийн Манлай  
сүлжн ЕБЛ-ийн сурал 9<sup>а</sup> ангийн Нэлшүүрэн  
Он сар: 2026.03.02  
Утас: 80909866  
Сургуулийн нийгэмийн ажигтан: Мангсүрэн  
-88855488



Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9а ангийн сурагч Нямаагийн Нэмүүлэн

*Сайн байна уу? Хорвоод хосгүй хонгорхон найз минь. Чи минь гал морин жилдээ цогтой шинэлсэн үү? Найз нь хөдөө гэртээ шинэ төлийн дуутай хамт хайртай хоёр буурайтайгаа болон гэр бүлийнхэнтэйгээ сайхан шинэлсэн. Миний хувьд анх удаа цаасан дээр өөрийнхөө гараар чамд захидал бичиж байгаадаа маш их баяртай байна. Ингээд найз нь чамд дижитал ертөнц болон хүн хоорондын харилцааны талаар өөрийнхөө үзэл бодлыг бичих гэсэн юмаа.*

*Цахим сүлжээ үүсэж хөгжсөнөөр бидний амьдралд зөндөө сайхан эерэг гайхалтай зүйлүүд бий болсон. Мэдээ мэдээлэл, дэлхий ертөнцийн сонин хачнаас цаг алдалгүй уншиж, мэдлэг боловсролдоо ч их хөрөнгө оруулж байгаа билээ. Хүмүүстэй маш хурдан холбогдож, мөнөөтэй холбоотой зарим асуудлуудыг гэрээсээ зохицуулах нь бидний амьдралыг үнэхээр хөнгөвчилж байгаа. Дижитал ертөнцийн эерэг талыг нь бичээд байвал маш их. Харин сөрөг тал нь ч магадгүй үүнээсээ их байж болзошгүй юм. Яагаад гэвэл хүмүүс цахим ертөнцөд хэт донтсоноос болж эрүүл мэндээрээ хохирч байгаа нь илэрхий харагддаг. Дэлгэцийн хамаарал бүхий хүний тархи нь бага багаар гэмтэж байдгийг судлаачид олж илрүүлсэн тухай уншсан. Мөн хүн хоорондын харилцаа бас хүйтэн хөндий ч юм шиг. Амьд харилцаа нь бидэнд дотно нөлөө үзүүлдэг бол цахим харилцаа нь дэлгэцийн цаанаас харилцдагаараа ялгаатай. Дүрст дуудлага хийсэн ч мэдрэмжээ нуучихдаг. Харин уулзаад яриад ирэхээр нэгнийхээ ямар байгааг илүү мэдэрч чаддаг. Надад хүнд хэцүү зүйл тохиолдоход чамайг санаа зовно гээд зүгээрээ гэж хэлдэг. Чи миний хажууд байсан бол ямар байгааг биеийн хэлэмжээр минь мэдэрч ойлгох байсан байхдаа. Найз минь чи шилжиж яваад 4 жил болжээ. Энэ хугацаанд бид хоёр цахим чатаар харилцаж байгаа хэдий ч чиний өөрчлөлтийг мэдэрч чадахгүйдээ хаяа гунигладаг. Зурагнаас чинь гадаад төрхийг чинь харж байгаа боловч дотоод ертөнцийн чинь өөрчлөлтийг мэдрэхийг хүсэж байна. Чамайг сумандаа байхад нүдийг чинь харж инээж, уурлахыг чинь мэдэрч хамтдаа цагийг зөндөө зугаатай өнгөрүүлдэг байжээ. Тэгэхээр дижитал ертөнц бол зүгээр л нэг хэрэглээ харин амьд харилцаа бол хүн байхын эхлэл юм байна. Нүүр номын хуудсыг эргүүлж харах тусам тэнд байгаа зарим хүмүүс хуурамч, бүдүүлэг, дээрэлхүү ч юм шиг. Сайн сайхан хүмүүс зөндөө л бий. Гэхдээ тэдний жинхэнэ нүүр царайг олж харна гэдэг бараг худлаа. Сошиал ертөнцөд сайхан дүр бүтээдэг муу хүн ч байна, өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлснээрээ муу болчихдог ч хүн байна. Энгийн хүмүүс фейсбук, инстаграм, ютүбээр бичлэг хийж олны танил болж байна. Зарим нь үнэхээр гоё үлгэр дуурайлал болохоор эерэг зүйлийг харуулдаг ч зарим нь ашиг хонжоо олохын тулд юу ч хийхээс буцахгүй харагддаг. Бодит үнэнг нь мэдэхгүй байж нэгнийгээ дижитал ертөнцөөр дээрэлхэж муухай үгээр гутаадаг ч байна. Тийм болохоор энэ ертөнцөд ухаантай, соёлтой байхгүй бол хохирогч болох эсвэл бухимдалтай, гутралтай болох ч энүүхэнд.*

*Сүүлийн үед том хүн хүүхдүүд ялгаагүй цахим тоглоомд донтох болсон. Цахим мөрийтэй тоглоом тоглож өрөнд орж амиа хорлосон тохиолдол ч зөндөө байдаг гэсэн нь үнэхээр харамсалтай. Ингээд бодохоор амьд харилцаа ямар их чухал гээч. Хэчнээн уйдахагүй байгаа мэт дижитал ертөнцөөр аяллаа л үнэндээ ганцаардлыг бий болгож байна. Дэлгэцийн цаанаас хэчнээн сайхан эможи явуулсан ч жинхэнэ тэврэлтийг гүйцэхгүй. Хамтдаа байж баяр гуниг жаргал зовлонг хуваалцах нь хамгийн сайхан зүйл. Хэрвээ бид муудалцлаа гэхэд хамт байгаа үедээ хэзээ ч нэгэндээ муухай үг хэлж чадахгүй. Нэгнийхээ нүд рүү харж байгаад доромжлох зоригтой хүн ховор байх. Харин дэлгэцийн цаанаас юу ч*

бичиж чадна. Нөхөрлөл дуусаж хоёулаа сэтгэлдээ гомдолтой үлдэнэ. Хүмүүс хамт байх цаг гаргаж уулзаж бие биедээ анхаарал халамж тавих нь чухал болжээ. Миний бодлоор сошиал хэрэглээгээ зөв зохистой, соёлтой болгох нь чухал асуудал юм. Зайлшгүй хэрэгцээтэй үедээ ашиглаад бусад үед ном унших, зааланд тоглохыг илүүд үзэх нь дээр.


Эцэст нь дижитал ертөнц маш хурдацтай хөгжиж ашиг тус нь их ч гэлээ тэнцвэртэй хандахгүй бол сүүдэртэй тал нь давамгайлаад байгаа харагдаад л байна. Харин амьд харилцаа бол илүү дулаахан, утга учиртай, дурсамжтай жинхэнэ мэдрэмжийн илэрхийлэл юм. Интернэт үүсэхээс өмнө хүмүүсийн харилцаа илүү дотно байж. Айл хөршийнхөөрөө орж гарч, нэг хорооллын хүүхдүүд хамтдаа тоглож бие биедээ илүү их анхаарал тавьдаг байсан. Дээр үед шуудан холбоо хүмүүсийн харилцааны гүүр болж холын харилцааг ойртуулж өгдөг байж. Захидал бичих, дугтуйнд хийж, шуудан холбоогоор илгээх нь орчин үед хоцрогдсон мэт хэдий ч олон сайхан давуу талтай санагдсан. Яагаад гэвэл манай ээж одоо болтол найзуудынхаа захиаг хадгалж байдаг. Ээжийн 10 жилийн болон оюутан цагийнх нь дурсамж тэр захидлуудад нь үлдэж байдаг гэсэн. Ээж нэг удаа шүүгээнийхээ юмыг цэгцэлж байгаад захидлуудаа уншаад аз жаргалтайгаар инээгээд байсан. Би тухайн үедээ ойлгоогүй ч одоо бодоход ээж минь хүүхэд насандаа эргэж очоод баярлаж байж. Чатны захидал нэг мэдэхэд л устаж байдаг бол цаасан захидлыг хадгалж дурсамжаа сэргээж болдог байх нь.

Мөн цаасан захидал бичихдээ хүмүүс үг үсэг, найруулгын алдаагүй, үгийн товчлолгүй цэгцтэй сайхан бичдэг нь бичгийн соёлд чухал үүрэгтэй санагдсан. Сошиал сүлжээнд автомат үсгийн фонтоор бичдэг бол цаасан захидал нь тухайн хүнийхээ бичгийн хэвийг цаасан дээр үлдээдгээрээ гайхалтай. Одоо үед хэн ямар бичгийн хэвтэйг багш нараас өөр хүмүүс бараг мэдэхгүй. Захианыхаа төгсгөлд хэлэхэд хоёулаа сардаа нэг удаа цаасан захидлаар харилцаж байя. Би удахгүй төгсөөд чам дээр очих болохоор үлдэх хугацаанд захидлаар харилцаж дурсамж болгож үлдээе. Хэзээ нэгэн цагт хадгалсан захидлаа уншиж аз жаргалтайгаар инээцгээе.

Захидал бичсэн: Өмнөговь аймгийн Манлай сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Н.Нэмүүлэн

## ШИЛДЭГ ЗАХИДЛУУДЫН ИШЛЭЛ:

Өмнөговь аймгийн Манлай сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Н.Нэмүүлэн



- Хэчнээн уйдахагүй байгаа мэт дижитал ертөнцөөр аяллаа ч үнэндээ ганцаардлыг бий болгож байна.
- Дэлгэцийн цаанаас хэчнээн сайхан эможи явуулсан ч жинхэнэ тэврэлтийг гүйцэхгүй.
- Сошиал сүлжээнд автомат үсгийн фонтоор бичдэг бол цаасан захидал нь тухайн хүнийхээ бичгийн хэвийг цаасан дээр үлдээдгээрээ гайхалтай.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1-р сургуулийн 6а ангийн сурагч С.Төгсжаргал

- Найзынхаа нүд рүү харж, чин сэтгэлээсээ инээмсэглэж, сэтгэлээ онгойтол ярилцах нь зөвхөн бодит харилцаанд л байдаг онцгой ид шид юм.
- Эцэст нь хэлэхэд, хэчнээн хурдан интернэт ухаалаг гар утастай байсан ч хүний халуун дулаан үг хэзээ ч чин сэтгэлийг орлож чадахгүй.



Хөвсгөл аймгийн Цагаан Уул сумын ЕБС-ийн 10а ангийн сурагч Н.Гэрэлсүрэн



- Дижитал хэрэглээ нь бидний сонголт, амьд харилцаа бол бидний мөн чанар. Бид бүгд дэлгэцийн цаанаас бус зүрх сэтгэлээ холбож дижитал ертөнц болон хүн хоорондын харилцаа хоёрыг зэрэг хөгжүүлэх боломжтой юм.
- Хэнтэй, хэдийд, юуг, хэрхэн, яаж ярихаас бидний амьдралын олон чухал шийдвэрүүд гарч байдаг.

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын ЕБС-ийн 8а ангийн сурагч М.Лхамсүрэн

- Хаанаас ч хэнтэй ч холбогдож болох XXI-р зуунд захидал бол сэтгэл хамгийн их мэдрэгдэж болох зүйл юм. Сэтгэл мэдрэгдэж, дурсамж ч үлдэнэ.



Завхан аймгийн Улиастай сумын Чандмань-Эрдэнэ сургуулийн 10в сурагч Ю.Ариунгоо



- Хэрвээ бидний хайр, нөхөрлөл, итгэл зөвхөн дэлгэцийн цаана үлдвэл амьд харилцааны үнэ цэн хаана үлдэх вэ?

Өмнөговь аймгийн Манлай сумын ЕБС-ийн 7а ангийн сурагч О.Эгшиглэн



- Зарим хүмүүс бусад хүмүүсийн хийдэг бичлэг дээр hate comment буюу үзэн ядаж муулсан сэтгэгдэл үлдээж байгаа нь сошиал ертөнцийн хүн хоорондын харилцаанаас гадна гэр бүлийн халуун дулаан уур амьсгал алдагдаж байгаа нь харамсалтай.
- Дижитал ертөнц бол хэн болгон нь нэгнийгээ хараан зүхэж болдог газар биш гэдгийг ухаарах хэрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Мөнхцацрал

- Цахим ертөнцтэй бид хөл нийлүүлэн амьдрах хэрэгтэй ч үүнийг ашиглан олон гэмт хэрэг, залилан гарч байгаа тул бүгдээрээ дижитал ертөнцийг зөв зохистой тохиромжтой үед нь хэрэглэж, хэмжээ хязгаартай ажиллаж сурцгаая!
- Манай 1-р ангийн бяцхан дүүгийн нэг өдрийн гар утасны хэрэглээ нь 3 цаг, харин минийх 5 цаг байсан. Гэхдээ би хэт их гар утас оролдсоноор хараа минь их муудаж, аливаа зүйлд анхаарал төвлөрөл муу, бие даан суралцах чадвар муутай болсноо анзаарч үүнийгээ дүүдээ давтуулахгүйн тулд утсандаа хязгаар тавьж хүснэгт бөглөдөг босон.



Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 17-р сургуулийн 9д ангийн сурагч Ш.Билгүтэй



- Миний найзууддаа анхааруулахыг хүссэн зүйл бол цахим орчинд хамаагүй дэлгэрэнгүй байхаас болгоомжлоорой.
- Технологи биднийг холбож байгаа ч жинхэнэ утгаараа хүмүүсийн ойлголцол, хүндлэл, зөв харилцаа л нийгмийг урагшлуулдаг гол хөдөлгүүр юм.
- Бидний бичсэн үг, илгээсэн мэдээлэл бусдад нөлөөлдөг учраас бодолтой, хариуцлагатай харилцах нь маш чухал билээ.

Өмнөговь аймгийн Манлай сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Т.Шинэцэцэг

- Магадгүй чиний санаандгүй, бодлогогүй бичсэн үгс дэлгэцийн цаана байгаа хүнд хэцүү байж магадгүй байх талаар сайн бодож тунгаах нь зөв.
- Дижитал ертөнц өөрөө муу биш. Харин бид түүнийг яаж ашиглаж байгаагаас бүх зүйл шалтгаалдаг.



- Бодит амьдрал дээрх нэг чин сэтгэлийн тэврэлт, нүд рүү эгцэлж харж хэлж буй урам зориг өгсөн үг, дэргэд сууж сонсох тэр мөчийг ямар ч технологи орлож чадахгүй.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЕБС-ийн 10б ангийн сурагч Х.Номин-Эрдэнэ



- Дижитал орчны соёл , амьд харилцааны соёл, ёс зүй нь өнөөгийн нийгэмд зайлшгүй хэрэгтэй чадваруудын нэг юм.
- Харилцаа бол зөвхөн ярих биш сонсох, ойлгох, хүндлэх үйл явц юм.
- Дижитал ертөнц бол зүгээр нэг технологийн хөгжил биш, харин хүний харилцааны шинэ орон зай хэлбэр юм.

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 17-р сургуулийн 9д ангийн сурагч Э.Солонго

- Яагаад заавал бидний харилцаа техник, технологи, дижитал хэрэглээтэй хамааралтай байх ёстой гэж? Зүгээр л хэрэглээ шүү дээ.
- Нэг зүйлээс сайн болон муу 2 дадлыг хэвшүүлж байна гэхээр бид л энэ зүйлийн тунг хэмжээг тааруулж зөвхөн мэдээллийн хэрэгсэл гэж хүлээж авах хэрэгтэй.



Дорноговь аймгийн Сайншанд сумын 1-р сургуулийн 7д ангийн сурагч А.Нандин-Эрдэнэ




- Хүн хоорондын харилцаа гэдэг нь зөвхөн мэдээлэл солилцох биш. Энэ бол бидний сэтгэл санаа бодол мэдрэмжээ дамжуулах хамгийн хүчтэй арга юм.
- Найзтайгаа нүүр тулж ярилцах, инээмсэглэж хоорондоо ойлголцох нь утас мессежээр хэзээ ч бүрэн орлуулж чадахгүй.

Өмнөговь аймгийн Манлай сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч М.Болор-Од

- Захидал гэдэг бол зүгээр уншаад өнгөрөх биш сэтгэл зүрхэнд хоногшин үлддэг үүрдийн мөнх үлддэг үгс юм.
- Хэрвээ энэ дижитал ертөнц байгаагүй бол чиний тухай мэдээллийг хэн нэгнээс сонсох, хэдэн сарын турш чамаас захиа хүлээж суух гээд маш удаан хүлээх байсан.
- Дижитал ертөнц хязгааргүй далай мэт боломж олгож, хол байгаа нэгнийг ойртуулдаг ч гэсэн яг дэргэд байгаа гэр бүл хайртай хүмүүсээс минь алгуурхан аажим аажмаар холдуулж байна.



Улаанбаатар хот Баянгол дүүргийн 20-р сургуулийн 9е ангийн сурагч М.Нарансолонго



- Дэлгэцийн цаанаас бид бие биедээ инээмсэглэж эможи илгээж болох ч, тэр нь чиний минь жинхэнэ инээдний дууг, нүдний чинь гэрэлтсэн харцыг хэзээ ч орлож чадахгүй байна.
- Дижитал ертөнц биднийг холбох гүүр болж байгаа ч тэр гүүрээр алхаж очих нь бидний сэтгэл зүрх юм шүү.
- Дижитал ертөнцөд бид хэдэн мянган зурвас солилцож болох ч яг одоо цаасан дээр дуссан миний сэтгэлийн дусал нулимсыг дижитал технологи хэзээ ч чамд минь дамжуулж чадахгүй.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1-р сургуулийн 6а ангийн сурагч Э.Энх-Үжин

- Хэдий дижитал орчин бидэнд олон сайн зүйлийг үзүүлж байгаа ч олон зууны тэртээх хүн хоорондын сэтгэлийн үгсийг хүүрнэх эрээн дугуйт цаасыг арай л гүйцэхгүй мэт.



Хүүхдүүд Та бүхнийг ирэх жилийн захидал бичлэгийн уралдаандаа амжилттай оролцохыг уриалж байна.

ШУУДАНГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР